



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 18

Номгон

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан "Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 1.1, 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнг баталгаажуулсугай.

Хоёр. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер Д.Цэцэгмаа, ахлах аудитор А. Цээням, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр нарт даалгасугай.

ДАРГА

Б. МӨНХБАТ

2517106

Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй  
тайлан

Огноо:2018.04.18

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	БНА-2018/01/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Баянхонгор аймгийн Засаг дарга
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор А.Цээням, аудитор Б.Цэрэнчимэд, Ж.Өсөхбаяр
Аудитын нэр:	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан		

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	1				1			
	ДҮН	1	1				1			

Гурав. Аудитын үр дүн

2.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Санхүүгийн тайланд залруулсан	
		Тоо	Дүн /сая төгрөг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
А	1	2	3	3	4	5	6	7	8	9	10
1	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	13	271,1	8	99,4			1	28,9	4	142,8
	ДҮН	13	271,1	8	99,4			1	28,9	4	142,8

## 2.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:

### Алдаа, зөрчилтэй асуудал 1

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс өмнөх 2007-2009 онуудад жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор ХАС банкинд байршуулсан 75.0 сая төгрөгийн эх үүсвэр, тус дансны үлдэгдэлд 2017 онд тооцсон 0.6 сая төгрөгийн сангийн үлдэгдэл болон хүүгийн орлогыг санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдэлээр тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

### Алдаа, зөрчилтэй асуудал 2

Аймгийн ИТХ-ын 2017.06.02-ы өдрийн 6/02 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017.08.08-ы өдрийн А/565 тоот захирамжаар ангилагдаагүй зардлаас 50.0 сая төгрөгийг Зээлийн батлан даалтын санд аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор гэрээ байгуулан олгож авлагаар тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

### Алдаа, зөрчилтэй асуудал 3

"Чандмань Баянхонгор" ХК амины орон сууцны дэд төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны "Орон сууцны санхүүжилт МОН-1847" төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр авсан урт хугацаат зээлийн үлдэгдэл 99.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

### Алдаа, зөрчилтэй асуудал 4

2017 онд "Баянхонгор Эрчим хүч" ЦТХК нь Дэлхийн банкнаас олгосон зээлээс тайлант онд төлөх хуваарийн дагуу зээлд 40.5 сая, хүүнд 8,2 сая, нийт 48,7 сая төгрөг төлсөн ч өмнөх онуудын зээлийн хугацаа хэтэрсэн 182.7 сая төгрөгийг төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Аймгийн ОНХС-аас олгосон зээлийн авлага 502,0 сая, Скейл ХХК-д олгосон 195.0 сая, нийт 697.0 сая төгрөгийн он дамжсан олон жилийн насжилттай авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.2-д заасан төсвийн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 6

Ангилалдаагүй зардлаас "Нэксст дистрибьюшн" ХХК-аас худалдан авсан 28,9 сая төгрөгийн үнэ бүхий компьютерийг аймгийн ЗДТГ-ын нярваар дамжуулан багийн Засаг дарга нарт тараасан байхад хөрөнгийг сумдууд орлого аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 7

Эмийн эргэлтийн сангуудын нэгтгэсэн тайланд тусгасан 16.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тайланд дутуу, Супрессор өрхийн эмнэлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

Алдаа, зөрчилтэй асуудал 8

Санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн ИТХ-ын авлагын эхний үлдэгдэлийг 0.05 сая төгрөгөөр дутуу, Оточномгон өрхийн эмнэлэгийн эхний үлдэгдэлийг 0.03 сая төгрөгөөр илүү, Баянговь сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэлийг 0.03 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн

аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн:

Ахлах аудитор

А.Цээням

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Танилцаж зөвшөөрсөн:

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат



Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.04.18	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:	БНА-2018/01/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Засаг дарга			Сая. төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа зөрчлийн утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Үндсэн хөрөнгийн данс	1	Эмийн эргэлтийн сангуудын нэгтгэсэн тайланд тусгасан 16.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тайланд дутуу, Супрессор өрхийн эмнэлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан байна.	17,1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	2018.04.15	-	Аймгийн ерөнхий бодогч	ТЕЗ-ийн нягтлан Ц.Самбууням
2	Авлагын дансны тулгалт	1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн ИТХ-ын авлагын эхний үлдэгдэлийг 0.05 сая төгрөгөөр дутуу, Оточномгон өрхийн эмнэлэгийн эхний үлдэгдэлийг 0.03 сая төгрөгөөр илүү, Баянговь сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэлийг 0.03 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.	0,1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	2018.04.15	-	Аймгийн ерөнхий бодогч	ТЕЗ-ийн нягтлан Ц.Самбууням

A	1	2	3	4	5	6	7	8	9
3	Мөнгөн хөрөнгө	1	Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс өмнөх 2007-2009 онуудад жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор ХАС банкинд байршуулсан 75.0 сая төгрөгийн эх үүсвэр, тус дансны үлдэгдэлд 2017 онд тооцсон 0.6 сая төгрөгийн сангийн үлдэгдэл болон хүүгийн орлогыг санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдэлээр тусгаагүй байна.	75,6	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	2018.04.15	-	Аймгийн ерөнхий бодогч ТЕЗ-ийн нягтлан	Ц.Самбууням
4	Мөнгөн хөрөнгө	1	Ангилалдаагүй зардлаас "Нэкст дистрибьюшн" ХХК-аас худалдан авсан 28996.0 мянган төгрөгийн үнэ бүхий компьютерийг аймгийн ЗДТГ-ын нярваар дамжуулан багийн Засаг дарга нарт тараасан байхад хөрөнгийг сумдууд орлого аваагүй байна.	28.9	Албан шаардлага өгсөн	2018.04.15	59	Аймгийн дарга, ОНӨГ-ын дарга, Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга	Ч.Мөнхцэцэг, Д.Ихбаяр
5	Мөнгөн хөрөнгө	1	Аймгийн ИТХ-ын 2017.06.02-ы өдрийн 6/02 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017.08.08-ы өдрийн А/565 тоот захирамжаар ангилагдаагүй зардлаас 50.0 сая төгрөгийг Зээлийн батлан даалтын санд аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор гэрээ байгуулан олгож авлагаар тусгаагүй байна.	50.0	Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан	2018.04.15		Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч	Г.Батжаргал, С.Байгалмаа, Ц.Самбууням

A	1	2	3	4	5	6	7	8	9
6	Авлага	1	Аймгийн ОНХС-аас олгосон зээлийн авлага 502,0 сая, Скейл ХХК-д олгосон 195.0 сая, нийт 697.0 сая төгрөгийн он дамжсан олон жилийн насжилттай авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.2-д заасан төсвийн зарчимтай нийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөв	2018.04.15		Аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч	Г.Батжаргал, С.Байгалмаа, Ц.Самбууням
7	Урт хугацаат өглөг	1	"Чандмань Баянхонгор" ХК Азийн хөгжлийн банкны "Орон сууцны санхүүжилт МОН-1847" төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдэл 99.4 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	99.4	Зөвлөмж өгөв	2018.04.15		Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч, "Чандмань Баянхонгор" ХК -ийн захирал, нягтлан бодогч	С.Байгалмаа, Ц.Самбууням, Э.Энхбат, Б.Наранцэцэг
8	Урт хугацаат өглөг	1	2017 онд "Баянхонгор Эрчим хүч" ЦТХК нь Дэлхийн банкнаас олгосон зээлээс хугацаа хэтэрсэн 182.7 сая төгрөгийг төлөөгүй байна.	-	Зөвлөмж өгөв	2018.04.15		Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга аймгийн ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч "Баянхонгор Эрчим хүч" ЦТХК -ийн захирал, нягтлан бодогч	С.Байгалмаа, Ц.Самбууням, Т.Отгонбаатар, Б.Батбаатар
	Дүн	8		271,1					

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан Тэргүүлэх аудитор:


А.Цээням

Б.Цэрэнчимэд

Ж.Өсөхбаяр

Д.Цэцэгмаа

Б.Мөнхбат







*Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар*

**Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн  
захирагчийн 2017 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан**

---

**Аудитын код: БНА-2018/1/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 99007576

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Цэцэгмаа  
Утас: 70442424, 88089024

Цахим хаяг: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)

Ахлах аудитор: А.Цээням  
Утас: 99442140

Цахим хаяг: [tseenyam.a@audit.gov.mn](mailto:tseenyam.a@audit.gov.mn)



### Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СЯ	Сангийн яам
ХАХНХЯ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон улсын стандарт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
МХС	Мал хамгаалах сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

## Нэг. Ерөнхий зүйл

### 1.1 Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.


### 1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэгдэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомжийн хүрээнд, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилго бөгөөд хамарсан асуудлууд болно.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 236 байгууллагуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнд:

#### Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн байгууллага



Дээрх хүснэгтээс харахад төсөвт 53 байгууллагад замын сан, ангилагдаагүй зардал орсон мөн орон нутгийн тусгай сан болох Сум хөгжүүлэх 20 сан, орон нутгийн хөгжлийн 21 сан. *Төсөв батлагдаж байгаагаас санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллагаар тайлагнагдаж байна!*

Мөн Орон нутгийн өмчит 6 байгууллагын тайлан. *Сумдын эргэлтийн эмийн сангийн 21 байгууллагыг нэгтгэсэн 1 санхүүгийн тайланг 1 байгууллагаар авлаа!*

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 113 байгууллагын санхүүгийн тайланд ТЗШ-ээс санхүүжилт авдаг 5 Өрхийн эрүүл мэндийн төвийг төсвийн гүйцэтгэлийн тайланг тохируулахын тулд төсөвт байгууллагаар нэгтгэсэн.

Орон нутгийн нөөц сан (*нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төвлөрүүлсэн*), ХО-ын техник хяналтын барьцаа дансыг нэгтгэсэн санхүүгийн тайланд сангаар нэгтгэгдэв.

### 1.3 Аудитын арга зүй

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, аудитын шинжилгээний болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ оршин байх, иж бүрэн байх, эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба илчлэл, үнэн зөв байх санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг шалгуур болголоо.

Аудитыг гүйцэтгэх хугацаа, боловсон хүчний нөөц хязгаарлагдмал байснаас шалтгаалан эрсдэлд суурилах, түүвэрлэх зэрэг аудитын олон улсын стандартад заасан арга, аргачлалыг аудит хийж санал дүгнэлт гаргахдаа ашигласан болно.

АОУС 320 болон холбогдох лавлагааны дагуу гүйцэтгэлийн үе шатанд 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт зарлагын дүнг суурь болгон, эрсдлийг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувийг 0.5 хувиар буюу 590.1 сая төгрөгөөр тогтоов. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын суурь үзүүлэлт өөрчлөгдөөгүй болно.

### 1.4 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Хүснэгт 1. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн бодлого, зарчим тодруулгууд
Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Толилуулгын суурь
Аймгийн ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
Өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу Засгийн газрын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн “Э-тайлан” санхүүгийн програм ашиглан гаргажээ.

Энэ нь бүх шатны төсвийн байгууллагуудын тайланг хамруулсан өгөгдлийн нэг баазтай болсон, интернетийн орчинд ажилладаг, хяналт, аудит хийх нөхцөлийг нэмэгдүүлж өгсөн давуу талтай. Харин санхүүгийн нэгтгэсэн тайланг загвар маягтад гараар шивж СТАУС програмд татуулж байгаа нь алдаа гарах, дахин давтан хянах эрсдэл үүсгэж байна.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа УСНББОУС-ын дагуу бэлтгэн гаргахыг зорьж, стандартад заасан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурийг хэрэглэсэн байна.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, УСНББОУС 12 “Бараа материал”-ийн стандартын дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэж, үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулсан.
- Санхүүгийн тайлангийн тодруулга нь хэлхээ холбоотой талуудын тодруулга, болзошгүй өр төлбөр зэрэг мэдээллийг бүрэн оруулсан байна.
- Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

#### **Хоёр. Санхүүгийн дотоод хяналт**

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх” гэж заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 7 орон тоотой ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/651 дугаар захирамжаар Дотоод аудитын хороог байгуулж бүрэлдэхүүнийг баталсан ба 2017 онд 8 удаа хуралдаж 34 тогтоол гарган 54 хүнд сахилгын шийтгэл ногдуулж санал хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна.

Тус алба 2017 онд 82 удаагийн хяналт шалгалт хийж 4 тусгай зориулалтын шилжүүлгийн, 73 төсөвт байгууллага, 5 санг хамруулсан байна.

Хяналт шалгалтаар 205 төлбөрийн актаар 657,2 сая төгрөгийн хохирол тооцож, орон нутгийн төсөвт 166,8 сая, тухайн байгууллагын дансанд 490,3 сая төгрөг оруулахаар шийдвэрлэснээс аймгийн төсөвт 52.0 сая төгрөг оруулж

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит төлбөрийн актын барагдуулалт 34,2 хувьтай байгаа нь СХС-ийн зээлийн эргэн төлөлтөд тавьсан төлбөрийн акт барагдаагүй байгаатай холбоотой байна.

Аймгийн Засаг даргатай 2017 онд байгуулсан үр дүнгийн гэрээ “хангалттай” гэж дүгнэгдсэн байна.

Харин Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар жил бүр илэрсэн алдаа, зөрчлийн дүн буурахгүй дахин давтагдан гарсаар байгаа нь цаашид эрсдэлд суурилсан шалгалтыг түлхүү хийхэд хүн хүчний нөөцөө ашиглахад илүү анхаарах шаардлагатай байна.

### **Гурав. Шилэн дансны мэдээлэл**

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагууд 2017 онд Шилэн дансны тухай хуулинд заасан мэдээллүүдийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нь байршуулж байгаа ба “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 оны 11 дүгээр сарын 20-д нийцлийн аудит хийсэн.

Аудитаар Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 - 3.1.3 дахь заалтад хамаарах, урьдчилсан судалгаагаар гарсан төрийн болон орон нутгийн өмчит **209** байгууллага, орон нутгийн өмчит “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХК, “Чандмань-Баянхонгор” ХК, **нийт 211** төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагджээ.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллага 20597 мэдээлэл байршуулахаас 19217 мэдээллийг байршуулсан хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 92.6 %, хуулийн 6.4-т заасан мэдээллийн 85.3%-ийг шилэн дансанд байршуулсан байгаа нь хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна гэсэн дүгнэлт өгч 706.1 сая төгрөгийн мэдээлэл оруулаагүй зөрчил илэрч 27 байгууллагад мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах албан шаардлага өгч, хэрэгжилтийг тооцон ажилласнаас үзэхэд өмнөх зөрчил дутагдал давтагдан гарсаар байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>1</sup>-т заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг 2017 оны 1.2-р улиралд хийгээгүй байна. 2017 оны 3,4 дүгээр улиралд хийсэн байна.

<sup>1</sup> “Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу ТЕЗ хэрэгжүүлнэ”  
АУДИТЫН КОД БНА-2018/1/СТА-ТЕЗ

## Дөрөв. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

### 4.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3917.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 369.1 сая төгрөг буюу 8.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+), Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
Кассад байгаа бэлэн мөнгө	6.7	0.6	0.6			-6.07
Төгрөг/ЖМС	6.7	0.6	0.6			-6.07
Банкинд байгаа бэлэн мөнгө	4,279.6	3,916.6	0.0	719.4	3,197.2	-363.0
Төгрөг	4,279.6	3,916.6		719.4	3,197.2	-363.0
Гадаад валют	0.0	0.0				0.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0				0.0
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	<b>4,286.3</b>	<b>3,917.2</b>	<b>0.6</b>	<b>719.4</b>	<b>3,197.2</b>	<b>-369.1</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>						0.0
Төрийн сан	1,682.0	892.5		0.1	892.4	-789.5
Төсөвт байгууллагууд	13.7	1,657.5		31.8	1,625.7	1643.8
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	771.5	612.5	0.6	611.9		-159.0
Төсөл, сангууд	1,819.1	754.7		75.6	679.1	-1064.4

Үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзэхэд төрийн сан 892.5 сая, төсөвт байгууллага 1657.6 сая, төсөл сан 754.7 сая, ОНӨҮГ-ийн байгууллагын харилцах дансны үлдэгдэл 612.5 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй гарсан байна.

2017 оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 892.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүнээс 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын данс 410.7 сая, аймгийн ОНӨО данс 481.6 сая төгрөгийн үлдэгдэл тус тус байна.

Аймгийн ОНӨО данс 481.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь төсөвт байгууллагын харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 280.0 сая төгрөг буцаан дансанд төвлөрсөн, төлөвлөгөөнөөс давсан орлогын 201.6 сая төгрөг үлдэгдлээр байна.


Төсөвт байгууллагын дансны үлдэгдэл 1657.5 сая төгрөг байгаа нь сум хөгжүүлэх сан 832.3 сая, орон нутгийн хөгжлийн 747.4 сая, замын сан 43,5 сая, мал хамгаалах сан 2.8 сая, өрхийн эмнэлгүүдийн үлдэгдэл 31.5 сая төгрөг тус тус байна.

### 4.2 Арилжааны банкин дахь харилцах дансны талаар:

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн арилжааны банкин дахь эцсийн үлдэгдэл 719.4 сая төгрөг байгаа ба ОНӨҮГ-ын харилцах дансны үлдэгдэл 85.0 хувийг эзэлж байна.



Баян-Овоо, Баянговь сумдын төрийн сангийн арилжааны банкин дахь үлдэгдэл 0.1 сая, төсөвт байгууллагуудын арилжааны банкин дахь үлдэгдэл 31.8 сая төгрөг байгаа нь Жаргалант сумын сум хөгжүүлэх сан 0.3 сая, өрхийн эрүүл мэндийн төвүүд 31.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.



#### 4.3 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой гарсан зөрчлийн талаар

##### Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс өмнөх 2007-2009 онуудад жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор ХАС банкинд байршуулсан 75.0 сая төгрөгийн эх үүсвэр, тус дансны үлдэгдэлд 2017 онд тооцсон 0.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдлээр тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2<sup>2</sup>-дэх заалтыг зөрчсөн байна.

#### Тав. Авлагын бүртгэл, тайлагнал

##### 5.1 Авлагын бүтэц

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн авлагын эхний үлдэгдэл 5323.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6144.9 сая төгрөгөөр тайлагнасан нь өмнөх онтой харьцуулахад 821.9 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын эцсийн үлдэгдлийн өсөлт бууралт дансдаар

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	сая.төг
				Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	42.1	16.4	-25.7	0.27%
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.5	0.3	-0.2	0.00%
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0	0.9	0.9	0.01%
Байгууллагаас авах авлага	551.5	712.7	161.2	11.60%
Хувь хүмүүсээс авах авлага	230.6	350.4	119.8	5.70%
Орон нутгийн хөнжлийн сангаас олгосон бусад тооцооны авлага	195.0	195.0	0	3.17%
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	4230.0	4869.2	639.2	79.24%
Засгийн газрын байгууллага бусад шатны төсөвт олгосон авлага	73.2	0	-73.2	0.00%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>5323.0</b>	<b>6144.9</b>	<b>821.9</b>	<b>100.00%</b>

<sup>2</sup> “14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” АУДИТЫН КОД БНА-2018/1/СТА-ТЕЗ

Хүснэгт 3а. Авлагын үлдэгдэл сум, ОНӨААН-ээр

№	Байгууллага	2016.12.31-ы үлдэгдэл	2017.1.2.31-ы үлдэгдэл	Өсөлт бууралт	зээлийн авлага	Байгууллага	2016.12.31-ы үлдэгдэл	2017.12.31-ы үлдэгдэл	Өсөлт бууралт	Үүнээс: зээлийн авлага
1	Галуут	175.4	172.9	(2.6)	170.8	Баацагаан	217.8	316.5	98.7	316.5
2	Баян-Овоо	149.9	153.3	3.5	148.1	Бөмбөгөр	173.2	191.8	18.5	172.7
3	Эрдэнэцогт	157.2	138.0	(19.3)	134.7	Өлзийт	236.2	232.0	(4.2)	213.3
4	Бууцагаан	196.7	216.5	19.8	213.1	Хүрээмарал	180.6	184.6	4.0	181.2
5	Жинст	179.3	149.8	(29.5)	148.3	Баянбулаг	178.9	186.1	7.2	183.8
6	Богд	121.3	139.2	18.0	130.2	Шинэжинст	168.3	126.4	(41.9)	123.5
7	Баянлиг	246.6	230.0	(16.7)	216.4	Баянцагаан	218.9	188.8	(30.1)	188.8
8	Баянговь	190.9	168.5	(22.4)	167.9	Баян-Өндөр	104.4	151.6	47.3	151.6
9	Гурванбулаг	175.7	172.7	(3.0)	163.3	Баянхонгор сум	763.4	733.3	(30.0)	716.4
10	Жаргалант	244.3	223.6	(20.7)	220.4	Баянхонгор ТШЗ	869.1	755.3	(113.8)	502.0
11	Заг	150.3	187.9	37.6	171.7	ОНӨААН-ийн үлдэгдэл	224.5	1,126.0	901.5	555.4
НИЙТ ДҮН							5,323.0	6,144.9	821.9	5,190.2

**5.2. Авлагын үлдэгдэл, тооцоо нийлэлт, насжилт:**

2017 оны жилийн эцсийн нийт авлагын үлдэгдлийг байгууллагууд тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан ба авлагын он дамжсан олон жилийн насжилттай аймгийн ОНХС-аас өмнөх онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийн авлага 502,0 сая, 2014 онд хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу авто зам болон дахин төлөвлөлтөд орсон газрыг чөлөөлж, нөхөн олговор олгох ажлын хүрээнд Скейл ХХК-д олгосон 195.0 сая, нийт 697.0 сая төгрөгийн авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.2<sup>3</sup>-д заасан төсвийн зарчимтай нийцэхгүй байна.

Дээрхи авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

**5.3 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар**

**Аудитын илрүүлэлт:**

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд Аймгийн ИТХ-ын авлагын эхний үлдэгдлийг 0.05 сая төгрөгөөр дутуу, Оточномгон өрхийн эмнэлгийн эхний үлдэгдлийг 0.04 сая төгрөгөөр илүү тусгасан.
- Баянговь сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын эцсийн үлдэгдлийг 0.03 сая төгрөгөөр дутуу тусгасан.
- Аймгийн ИТХ-ын 2017.06.02-ы өдрийн 6/02 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017.08.08-ы өдрийн А/565 тоот захирамжаар ангилагдаагүй зардлаас 50.0 сая төгрөгийг Зээлийн батлан даалтын санд аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор гэрээ байгуулан олгосон байна. Гэрээний 2.5<sup>4</sup> дэх заалтыг үндэслэн санд төлсөн 50.0 сая төгрөгийг тайланд авлагаар тусгаагүй байна.


<sup>3</sup> “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”

<sup>4</sup> “Аймгаас санд оруулсан хөрөнгийг хамтран ажиллах гэрээний хугацаа дуусгавар болох, гэрээнээс гарах тохиолдолд түүгээр баталгаажуулан олгосон батлан даалттай зээл төлөгдөж дуусах хугацаатай уялдуулан буцаан татна.”

## Зургаа. Бараа материалын бүртгэл, тайлагнал

### 6.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /сая.төг/



Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл 4840.3 сая төгрөг байснаас 1760.6 сая төгрөгөөр өсч 6600.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үүнээс 87.1 хувийг төсөвт байгууллага, 12.9 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдлийг дансны бүтцээр: /сая.төг/

Бараа материалын нэр	2015 оны эцсийн үлдэгдэл	2016 оны эцсийн үлдэгдэл	2017 оны эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	729.7	789.0	1,001.8	212.8	15.18%
Эм боох материал	15.4	21.6	32.4	10.8	0.49%
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0.0	71.8	71.8	1.09%
Бэлэн бүтээгдэхүүн	24.7	24.6	68.5	43.9	1.04%
Бичиг хэргийн материал	128.8	144.5	163.5	19.0	2.48%
Аж ахуйн материал	1917.1	2,091.1	2,563.1	472.0	38.83%
Сэлбэг хэрэгсэл	31.2	33.0	36.4	3.4	0.55%
Түлш шатахуун, тослох материал	149.4	112.3	51.1	-61.2	0.77%
Барилга засварын материал	42.1	42.2	38.8	-3.4	0.59%
Хүнсний материал	70.4	103.2	70.7	-32.5	1.07%
Бусад хангамжийн материал	799.4	965.1	1,402.7	437.6	21.25%
Мал амьтад	232.6	275.8	271.7	-4.1	4.12%
Нөөцийн бараа	215.1	237.9	828.4	590.5	12.55%
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4,355.9</b>	<b>4,840.3</b>	<b>6,600.9</b>	<b>1,760.6</b>	<b>100.0%</b>

### 6.Үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал:

Тайлант онд 489.6 сая төгрөгийн бараа материалыг хандиваар, 400.8 сая төгрөгийг үнэ төлбөргүйгээр авсан ба 198.0 сая төгрөгийн бараа материалыг холбогдох шийдвэрийн дагуу акталж данснаас хассан, ХБХХТөв нь бүтцийн өөрчлөлтөөр шилжсэнтэй холбоотой 36.5 сая төгрөгийг бараа материал хасагдсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын тайлан сая.төг


Үзүүлэлт	Дүн
Эхний үлдэгдэл	4840.3
Нэмэгдсэн	9593.0
Худалдан авсан	8560.3
Хандиваар	489.6
Шилжүүлэн авсан	142.3
Бусад	400.8
Хасагдсан	7832.4
Худалдсан буюу зарцуулсан	7493.3
Шилжүүлсэн	104.6
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	36.5
Бусад	198.0
Эцсийн үлдэгдэл	6600.9

## Долоо. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

### 7.1 Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүний талаар:

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 227067.7 сая төгрөгөөр тайлагнагдсан ба үүнээс 90.2 хувийг төсөвт байгууллага, 9.8 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө байгаагаас нийт хөрөнгийн 97.4 хувийг биет хөрөнгө, 2.6 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /сая.төг/



- ОНТөсөвт байгууллага
- ТЗШ-ийн байгууллага
- ОНӨААН

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл дансаар

сая.төг

Ангилал	2017 оны эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
Барилга байгууламж	166,431.4	78.4%
Тээврийн хэрэгсэл	6,565.0	3.1%
Машин тоног төхөөрөмж	16,356.4	7.7%
Тавилга эд хогшил	6,991.7	3.3%
Зам, гүүрийн байгууламж	921.5	0.4%
Батлан хамгаалах	2.6	0.0%
Түүх соёл, музейн дурсгалт	961.3	0.5%
Дуусаагүй барилга	2,801.5	1.3%
Биет бус хөрөнгө	600.8	2.6%
Бусад үндсэн хөрөнгө	25,435.5	12.0%
<b>ДҮН</b>	<b>227067.7</b>	<b>100.0%</b>

### 7.2 Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 212282.8 сая төгрөг байснаас 17496.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 2711.6 сая төгрөгөөр хасагдаж тайлант оны эцэст 227067.7 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт

сая.төг

Ангилал	2016 оны эцсийн үлдэгдэл	2017 оны эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга байгууламж	158,003.9	166,431.4	8,427.5
Тээврийн хэрэгсэл	6,015.6	6,565.0	549.4
Машин тоног төхөөрөмж	15,153.1	16,356.4	1,203.3
Тавилга эд хогшил	6,249.0	6,991.7	742.7
Зам, гүүрийн байгууламж	789.0	921.5	132.5
Батлан хамгаалах	2.6	2.6	-
Түүх соёл, музейн дурсгалт	959.2	961.3	2.1
Дуусаагүй барилга	3,085.8	2,801.5	(284.3)
Биет бус хөрөнгө	594.7	600.8	6.1
Бусад үндсэн хөрөнгө	21,429.9	25,435.5	4,005.6
<b>ДҮН</b>	<b>212,282.8</b>	<b>227,067.7</b>	<b>14,784.9</b>

2017 онд орон нутгийн төсөвт байгууллагууд УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын 2-т төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр, 2.в бараа үйлчилгээний зардлыг бууруулах, 2.в..3-т “тавилга шинээр худалдан авахгүй байх” гэсэн заалтыг зөрчин 61 байгууллага 202,8 сая төгрөгийн тавилгыг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн байна. Иймд цаашид төсвийг хэмнэлттэй зарцуулах, хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар аудитын явцад зөвлөж ажиллав.

### 7.3 Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл 71493.8 сая байснаас тайлант хугацаанд 10746.2 сая төгрөгийн элэгдэл байгуулж, өмнөх оны элэгдлийн зөрүү 132,3 сая төгрөг, данснаас хасагдсан хөрөнгөнд ногдох 1213,1 сая төгрөгийн элэгдлийн хасагдуулга хийж, оны эцэст 80894.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэлтэй байна.

### 7.4 Улсын төсвөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн үндсэн хөрөнгө

Улсын төсвөөс орон нутгийн өмчид шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

### 7.5 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчлүүдийн талаар

#### Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Эмийн эргэлтийн сангуудын нэгтгэсэн тайланд тусгасан 16.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу, Супрессор өрхийн эмнэлгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 0.2 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тусгасныг залруулав.

### Найм.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

#### 8.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар

Нийт өр төлбөр оны эхэнд 1172.3 сая төгрөг байснаас 709.1 сая төгрөгөөр нэмэгдэж 1881.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийт өр төлбөрийн дүнд ОНӨҮГ-ын өглөг 78.7 хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 8. Нийт өр, төлбөрийн дансны ангилал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>1,172.3</b>	<b>1,881.4</b>	<b>709.1</b>	<b>100</b>
Богино хугацаат өр төлбөр дүн	141.3	754.6	613.3	40.1
Урт хугацаат өр төлбөр дүн	1,031.0	1,126.8	95.8	59.9
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>				
Төсөвт байгууллага	40.7	116.8	76.1	6.2
Төрийн сан	0.00	283.6	283.6	15.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,131.6	1,481.0	349.4	78.7

Дээрхи өглөгөөс төрийн сангийн 283.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит санхүүжилтээс баталгаа болгон суутган хоцорсон мөнгөн хөрөнгийг өглөгөөр тусгасан байна.

Төсөвт байгууллагуудын өглөг өмнөх оноос 76.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Жинст сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын өглөг 15.0 сая, Баянцагаан сумын ОНХО-д нөхөн сэргээлтийн барьцаа 30.3 сая, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 12 дугаар сард Эрүүл мэндийг дэмжих сангаас ирсэн санхүүжилт 34.2 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

## 8.2 Урт хугацаат өр төлбөрийн талаар:

Нийт урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1126.8 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 95.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Хүснэгт 9. Урт хугацаат зээлийн үлдэгдэл

сая.төг

№	Байгууллага	2016.12.31-ний үлдэгдэл	2017.12.31-ний үлдэгдэл	Гэрээний хугацаа	Хугацаа хэтэрсэн /үндсэн/	хугацаа хэтэрсэн /хүү/	Үлдэгдэл	
							баталгаа жуулсан	баталгаажуулаагүй
<b>Гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээл</b>								
<b>Азийн хөгжлийн банк</b>								
1	"Чандмань Баянхонгор" ХК МОН-1847	99.4	99.4	2007.06.16 2025.11.30	0	0	-	99.4
2	"Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх" ХХК МОН-1847	36.3	32.3	2006.04.19 2025.11.30	-	-	32.3	-
<b>дүн</b>		<b>135.7</b>					<b>32.3</b>	<b>99.4</b>
<b>Дэлхийн банк</b>								
1	"Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх" ХХК - МОН 3503	895.3	858.8	2006.11.27 2036.10.01	182.7		858.8	-
<b>дүн</b>		<b>895.3</b>	<b>858.8</b>		<b>182.7</b>		<b>858.8</b>	<b>0.0</b>
<b>Гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн</b>		<b>1030,9</b>	<b>990.4</b>		<b>182.7</b>		<b>891.1</b>	<b>99.4</b>
<b>Дотоодын эх үүсвэрээс авсан зээл</b>								
<b>"Чандмань Баянхонгор" ХК МОН-1847</b>								
Хас лизинг ХХК		0	68.7	2017.02 сар- 2021.02 сар			68.7	
ХААН банк		0	67.7	2017.06 сар- 2024.06 сар			67.7	
<b>Дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн</b>			<b>136.4</b>				<b>136.4</b>	
<b>НИЙТ УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>1031.0</b>	<b>1126.8</b>		<b>182.7</b>		<b>1027.5</b>	<b>99.4</b>

"Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК Дэлхийн банкнаас 2003 онд авсан зээл нь анх долларын зээл байсан бөгөөд 2012.03.01-нд төгрөгийн зээл рүү хөрвүүлэн гэрээг шинэчлэн байгуулсан байна. Энэхүү зээлээр Баянхонгор сумын Гэр хорооллын 04 квт-ын ЦДАШС-г сайжруулах ажлыг гүйцэтгэсэн.

"Чандмань Баянхонгор" ХК Баянхонгор аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2005.10.12-ны өдрийн 117 тоот тогтоолоор амины орон сууцны дэд төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны "Орон сууцны санхүүжилт МОН-1847" төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээгээр Баянхонгор аймгийн Номгон 1-р багт хэрэгжих "Шинэ төгөл" орон сууцны хорооллын гадна дулаан, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам, уурын зуухны барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж 197.6 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

*Дээрхи зээлээс Аймгийн ИТХ-ын 2016.10.11-ны өдрийн 3/4 тоот тогтоолоор ангилагдаагүй зардлаас хувьчилсан хөрөнгөнд ногдох 58.2 сая төгрөгийг төлөх шийдвэр гарч зээлийн дансанд 2016.12.22-нд төлснөөс зээлийн эргэн төлөлтийн хуваариас 18,0 сая төгрөгийг урьдчилан төлсөн байна. Тухайн зээлийн үлдэгдлийг "Чандмань Баянхонгор" ХК нь тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.*

*2017 онд "Баянхонгор Эрчим хүч" ЦТХК нь Дэлхийн банкнаас олгосон зээлээс тайлант онд төлөх хуваарийн дагуу зээлд 40.5 сая, хүүнд 8,2 сая, нийт 48,7 сая төгрөг төлсөн ч өмнөх онуудын зээлийн хугацаа хэтэрсэн 182.7 сая төгрөгийг төлөөгүй гэрээний үүргээ зөрчсөөр байна.*

Иймд гадаадын зээлийн хөрөнгөөс АЗДТГ-аар дамжуулан зээлдүүлсэн Чандмань-Баянхонгор ХК, Баянхонгор Эрчим хүч ЦТХК-ийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## **Ес. Орлого, татаас санхүүжилтийн талаар:**

### **9.1 Орлого, татаас санхүүжилтийн талаар:**

Аймгийн Засаг дарга 2017 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу аймгийн боловсролын салбарт 32807,2 сая, эрүүл мэндийн үйлчилгээнд 5454,5 сая, ГХБХБГазарт 244,1 сая, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэст 145,4 сая, нийт 38651,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр авч, оны эцэст харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 36,4 сая, өөрийн орлогоос 0,9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Аймгийн орон нутгийн төсөвт улсын төсвөөс 12251,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс 9136,0 сая төгрөгийг авч, оны эхний үлдэгдлээс 789,6 сая төгрөгийг олгон оны эцэст зарцуулагдаагүй харилцах дансны үлдэгдэл 260,7 сая, өөрийн орлогоос 19,5 сая төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудад 22457,2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн ОНХС-д улсын төсвөөс 2163,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирснийг хуваарийн дагуу олгосон байна.

### **9.2 Өөрийн орлого**

2017 онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 4448,8 сая төгрөг оруулжээ.

Орлогыг нэр төрлөөр ангилбал ОНХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс 37.4 сая, хандив, тусламжийн орлого 2744.7 сая, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос 1309,0 сая, орон нутгийн зам ашигласны хураамжаас 117.5 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 240,2 сая төгрөг оржээ.

### 9.3 Орон нутгийн төсвийн орлого, гүйцэтгэл

#### 9.3.1 Орон нутгийн төсвийн нийт орлого:

Аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 дугаар тогтоол, сумын ИТХ-ын тогтоолоор 2017 онд аймгийн нийт орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг 60264,6 сая төгрөгөөр баталж, төсөвт 3 удаа тодотгон 9380,6 сая төгрөгөөр өөрчлөлт оруулан 69645,2 сая төгрөгийн орлого оруулж, зарцуулахаар төсөв батлагдсан байна.

Хүснэгт 10. 2017 оны аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөний өөрчлөлт

№		Үзүүлэлт	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өөрчлөлт
1	A	Аймгийн нийт орлогын дүн	60,264.6	69,645.2	9,380.8
1	1	Орон нутгийн нийт орлогын дүн	8297.7	13448.4	5150.7
2	1.1	Урсгал орлогын дүн	6,652.6	8102.7	1450.2
3		Татварын орлого	6,009.7	7210.5	1200.8
4		татварын бус орлогын дүн	642.9	892.2	249.3
5	1.2	ТБӨОрлого	1,045.2	2433.3	1388.1
6	1.3	Хандив, тусламжийн орлого	300.0	2481.8	2181.8
7	1.4	Хөрөнгийн орлого	300,0	430,6	130,6
8	2	Тусламжийн орлого	51,745.6	53,206.8	1,461.2
9		Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг	11,082.6	12,251.4	1,168.8
10		Улсын төсвөөс ОНХС орлогын шилжүүлэг	2,980.0	2,163.3	(816.7)
11		Улсын төсвөөс Тусгай зориулалтын шилжүүлэг	37,559.5	38,651.3	1,091.8
12		ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	123.5	140.8	17.3
13	3	Урд оны үлдэгдлээс санхүүжих	221.2	2,990.0	2,768.9
14	B	Зарцуулах төсөв	60,264.6	69,645.2	9,380.6
15		Орон нутгийн төсөвт байгууллага, сан	18,894.0	24,903.1	6,009.1
16		Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагад	37,683.0	38,792.0	1,109.0
17		ОНХС-ын ТАХ	3,687.6	5,950.1	2,262.5

#### 9.3.2 Орон нутгийн орлогын төлөвлөлтийн талаар.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ны өдрийн 4/02 тоот тогтоол, сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 6652,7 сая, хөрөнгийн орлогоор 300,0 сая, хандив тусламжийн орлогоор 300,0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1045,2 сая /үүнд: орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоос 49,7 сая, ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 90,0 сая, , орон нутгийн зам ашигласны төлбөрөөр 90,0 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг 815,5 сая/, нийт орон нутгийн орлогыг 8297.9 сая төгрөгөөр орлогыг анх баталсан байна.



Аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсөвт 3 удаа тодотгол хийж 5150,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2017.11.27-ны өдрийн хуралдааны 7/01 дугаар тодотголоор орлогыг орон нутгийн татварын орлогыг 7210,5 сая, хөрөнгийн орлогыг 430,6 сая, татварын бус орлого 892,2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2433.3 сая /үүнд: орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогоос 133,5 сая, орон нутгийн зам ашигласны төлбөрөөр 116,1 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг 2183.7 сая/, хандив тусламжийн орлогоор 2481.8 сая нийт 13448.4 сая төгрөгөөр батлагдсан байна.

**Хүснэгт 11. Орлогын төлөвлөгөө**

сая.төг

Д/Д	Орлогын төрөл	Орлого		Өөрчлөлт
		Анх батлагдсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	
	<b>Орон нутгийн нийт орлого</b>	<b>8,297.9</b>	<b>13,448.4</b>	<b>5,150.5</b>
1	татварын орлогын дүн	6,309.8	7,641.1	1,331.3
18	Татварын бус орлого	642.9	892.2	249.3
19	Хүү торгууль	642.9	892.2	249.3
20	ТБӨО	1,345.2	4,915.1	3,569.9

**9.3.3 Гүйцэтгэлийн талаар :**

2017 онд аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаанаар орон нутгийн орлогоор 8297,9 сая төгрөг оруулахаар анх төлөвлөж, 3 удаагийн хуралдаанаар 5150,5 сая төгрөгөөр нэмж тодотгож, 13448,4 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс 13584,8 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 101,0 хувиар буюу 136,4 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 67,2 хувь буюу 9136,0 сая төгрөгийг татварын, 32,8 хувь буюу 4448,8 сая төгрөгийн орлогыг татварын бус орлогоор бүрдүүлсэн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

**Хүснэгт12. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт**

Сая.төг

Д/Д	Орлогын төрөл	орон нутгийн жилийн эцсийн тайлангаар			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Зөрүү
1	<b>А.Орон нутгийн нийт орлого</b>	13,448.4	13,584.8	101.0	136.3
2	татварын болон татварын бус орлогын дүн	8,533.3	9,136.0	107.1	602.8
3	<b>1.Аймгийн төсөв</b>	4,953.7	5,294.4	106.9	340.7
	1. ЦХТАО /суутган-1/	4,977.0	5,268.7	105.9	291.7
	Буцаан олголт	(772.0)	(771.4)	99.9	0.6
	2. АТӨЯХАТ	428.7	399.7	93.2	(29.0)
	3. Үл хөдлөх хөрөнгийн татвар	200.0	247.6	123.8	47.6
	4.Газрын төлбөр	120.0	149.8	124.8	29.8
2	<b>2. Орон нутгийн төсөв</b>	3,579.6	3,841.6	107.3	262.2
1	<b>Хүн амын орлого</b>	686.6	632.3	92.1	(54.3)
	1..ИОТТХ	686.6	632.3	92.1	(54.3)
2	<b>2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны</b>	72.5	90.4	124.7	17.9

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

2	Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого	430.6	315.1	73.2	(115.5)
3	3. Бууны татвар	46.1	52.7	114.2	6.5
4	5. Бусад төлбөр хураамж	1,451.4	1,607.8	110.8	156.3
	а.УТХ	221.2	231.7	104.7	10.5
	в. Газрын дуудлага худалдаа	2.5	8.2	325.4	5.7
	д. Хог хаягдлын хураамж	282.9	302.0	106.7	19.0
	д.ус рашаан ашигласны төлбөр	403.0	438.9	108.9	35.9
	ё.Түгээмэл тархацтай АМАТөлбөр	14.7	8.5	57.6	(6.2)
	з.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	520.0	603.0	115.9	82.9
	й.Нохойны татвар	7.1	9.0	126.7	1.9
	е.Бусад татвар		6.7	#DIV/0!	6.7
6	Татварын бус орлого	892.2	1,143.4	128.2	251.2
	Хүү торгууль	892.2	1,143.4	128.2	251.2
7	ТБӨО	2,433.3	1,666.7	68.5	(766.6)
	Хандив	2481.8	2,782.1	112.1	300.3

Дээрх орон нутгийн төсвийн орлогын мэдээнээс харахад аймгийн төсөвт төвлөрөх орлого 106,9 хувь буюу 340,5 сая, орон нутгийн орлого 107,3 хувь буюу 262,2 сая, хүү торгуулийн орлого 128,2 хувь буюу 251,2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Харин төсөвт байгууллагын өөрийн орлого 68.5 хувь буюу 766.6 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд ОНХС, СХС-гийн орлого, зарлагыг оруулан баталж, гүйцэтгэлийг тайлагнах болсноор сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзвэл АТБӨЯХАТатвар 29.0 сая төгрөгөөр тасарсан нь 2017 онд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТЕГ-ын даргын 2017.01.09-ны өдрийн А/08 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2017.03.16-ны өдрийн А/196 тоот захирамж, ТЕГ-ын тушаалаар баталсан удирдамжийн дагуу хуулийн этгээд, хувь хүний эзэмшилд байгаа АТБӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөрийг хураах ажлыг нутаг дэвсгэрийн зарчмаар аймгийн хэмжээнд зохион байгуулсан ч бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн татварыг бүрэн оруулаагүй зэргээс шалтгаалжээ.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Татварын хэлтсийн төсвийн орлогын мэдээтэй тулган шалгахад 9 сум 6 төрлийн татварын орлогыг 103.0 сая төгрөгөөр нэмж сумын ИТХ-ын хуралдаанаар тодотгосон байхад аймгийн Татварын хэлтсийн татварын төлөвлөгөөний мэдээнд сумдын татварын байцаагч нар мэдээлээгүй байна. Энэ нь аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, сумын Санхүүгийн албаны хоорондын ажлын уялдаа

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит хангалтгүйгээс жил бүр татварын орлогын төлөвлөгөө зөрүүтэй тайлагнагдаж байна.

*Тухайлбал: Галуут сум 31.5 сая, Баян-Овоо сум 9.0 сая, Эрдэнэцогт сум 9.5 сая, Бууцагаан сум 9.0 сая, Заг сум 0.8 сая, Өлзийт сум 11.9 сая, Хүрээмарал сум 1.0 сая, Баянбулаг сум 12.0 сая, Жинст сум 18.3 сая, төгрөгийн тодотгосон татварын төлөвлөгөөний мэдээг мэдээлээгүй байна.*

*Мөн аймгийн Татварын хэлтэс аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогын 430.6 сая төгрөгний төлөвлөгөөг оруулж тооцоогүй байна.*

## Арав: Зардлын бүртгэл, тайлагнал

### 10.1 Зардлын бүтцийн талаар

Тайлант оны аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 88785.5 сая төгрөгөөр тайлагнагдсан нь өмнөх оноос 1841.5 сая төгрөгөөр буурсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2017 оны нийт зардлыг эдийн засгийн ангиллаар харахад 94.9 хувь буюу 84234.2 сая төгрөгийг урсгал зардалд, 5.1 хувь буюу 4551,3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Тайлант оны зардлыг дотор нь бүтцээр нь харуулбал:



Тайлант оны зардлыг өмнөх онтой харьцуулбал урсгал зардал 1395.4 сая, хөрөнгийн зардалд 446,0 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт буурсантай холбоотой байна.

Хүснэгт 13. Нийт зардлыг өмнөх онтой харьцуулсан судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	2016 он	2017 он	ЭЗЛЭХ ХУВЬ	өмнөх оноос өөрчлөлт
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,626.8	88,785.5	100.0	(1,841.4)
УРСГАЛ ЗАРДАЛ	85,629.5	84,234.2	94.9	(1,395.4)
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,444.2	70,132.7	79.0	6,688.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	28,783.3	28,750.2	41.0	(33.1)

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,057.8	3,167.2	4.5	109.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,646.7	5,272.0	7.5	625.3
Хангамж, бараа материалын зардал	1,426.6	1,755.3	2.5	328.7
Нормативт зардал	2,640.0	2,707.1	3.9	67.1
Эд хогшил, урсгал засварын зардал	345.9	568.9	0.8	223.0
Томилолт, зочны зардал	218.2	266.8	0.4	48.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,332.2	5,296.5	7.6	964.2
Бараа үйлчилгээний бусад зардал	17,993.5	22,348.8	31.9	4,355.3
<b>ТАТААС</b>	<b>29.1</b>	<b>33.6</b>	<b>0.0</b>	<b>4.5</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,156.2</b>	<b>14,067.8</b>	<b>15.8</b>	<b>(8,088.4)</b>
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ				-
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,997.3</b>	<b>4,551.3</b>	<b>5.1</b>	<b>(446.0)</b>

Сумдын тайлант оны зардлын гүйцэтгэлээс харахад өмнөх оноос зардал дунджаар 3,5 хувиар өссөн байна.



## 10.2 Ангилагдаагүй зардал

Ангилагдаагүй зардлын дансанд 2017 онд 2445,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ний өдрийн 4/2 тоот тогтоолоор ангилагдаагүй зардалд 13 хөтөлбөр арга хэмжээнд 472,7 сая төгрөг баталж 2017 онд 3 удаа тодотгол хийж, нийт 2311,6 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 2310,8 сая төгрөг олгожээ.

Тухайн дансаар ахмадын байгууллагын санхүүжилтийн 75,2 сая, нийтийн тээврийн санхүүжилтийн 18,0 сая төгрөгийн гүйлгээ дамжсан бөгөөд дансны нэр зөрүүтэйгээс буцсан 491,9 сая төгрөгийн гүйлгээ гарсан байна.

ИТХ-ын тогтоолоор батлагдсан гадаад арга хэмжээний зардалд олгосон 2 удаагийн томилолтоос 1,3 сая, аймгийн Биеийн тамир, спортын газраас 0,2 сая, Гэр

бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 3,0 сая, Эрүүл мэндийн газраас 0,1 сая, нийт 4,6 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг буцаан дансанд төвлөрүүлж, оны эцэст дансны зарцуулаагүй үлдэгдлийн 41,1 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Ангилалдаагүй зардлаас аймгийн ИТХ-аар баталж орон нутгийн өмчит “Нью майнинг” ХХК-д үйл ажиллагааны зардалд 26,0 сая, “Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д төрийн ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр 65,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **10.3 Хуримтлагдсан үр дүнгийн талаар**

2017 оны аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн 6248.6 сая төгрөгөөр тайлагнагдаж, нийт хуримтлагдсан үр дүн 65912.9 сая, Засгийн газрын хувь оролцоо 66376.0 сая, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 28806,2 сая, нийт цэвэр өмчийн дүн 161095.1 сая төгрөг байна.

#### **Арван нэг. Аймгийн төсвийн шууд захирагч, сумдын ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар**

##### **11.1.Төсвийн шууд захирагч, тусгай сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар.**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу санхүүгийн тайланд нэгтгэгддэг 249 байгууллагаас 38 байгууллагад итгэл үзүүлж, 7 байгууллага түүвэрт хамруулж, 203 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулан, дүгнэлт гаргажээ. Үүнд орон нутгийн төсвийн 38 байгууллага, 15 сумын ТЕЗ, орон нутгийн тусгай сан 41, орон нутгийн өмчит 24 аж ахуйн нэгж, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 85 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдсан байна.

Монгол улсын Ерөнхий аудиторын 2015 оны 240 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шалгуурыг хангасан 38 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгээгүй.

Аудитад хамрагдсан нийт 203 байгууллагын санхүүгийн тайлангийн 11,8% буюу 24 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргаж, 2 тайланд “Дүгнэлт өгөхөөс татгалзах” дүгнэлт өгч, бусад тайлангуудад “Зөрчилгүй” санал дүгнэлт өглөө.

Аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан байгууллагын тоо өмнөх оноос 97-оор нэмэгдсэн нь өмнөх 3 жилд сумдын ИТХ, Соёлын байгууллагуудад итгэл үзүүлж аудит хийгдээгүй, 2017 оноос ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан гаргуулж, аудит хийж дүгнэлт гаргасан, сумдын Эмийн эргэлтийн сангуудын тайланд аудит хийсэнтэй холбоотой ба зөрчилтэй болон хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос 23-аар нэмэгдсэн байна.

Аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн зарим батламж мэдэгдэлтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчлүүд илэрсэн нь зарим төсвийн шууд захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх санал дүгнэлтийг хязгаарласан.

Хүснэгт14. “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал, дүгнэлт авсан ТШЗ	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Баянлиг сумын бага сургууль	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх заалтыг зөрчиж "Өнө мөнхөд дэлгэрэх" ХХК-иас хөрөнгө худалдан авахаар 3,8 сая төгрөгийг шилжүүлээд хөрөнгөө хүлээж аваагүй байхад орлого авч санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэсэн, бараа материалын орлого зарлагыг нярвын тайланд бүрэн тусгадаггүйгээс тайлант хугацаанд 2,0 сая төгрөгийн орлого, 2,3 мянган төгрөгийн зарлагыг дутуу тусгаснаас нярвын тайлан 0,3 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа зэрэг алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
2	Баянговь сумын Сум хөгжүүлэх сан	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2.б-д заасны дагуу ИТХ-аас сангийн төсвийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.2, 1.8, 3.5.7 дахь заалтыг зөрчиж "ЭЙ АР БИ СИ" ХХК-д 10.0 сая төгрөгийн зээлийг олгосон нь санхүүгийн тайлангийн "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
3	Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сан	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2.б-д заасны дагуу ИТХ-аас сангийн төсвийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 1.8, 3.5.7 дахь заалтыг зөрчиж иргэн Б.Батцэнгэлтэй 12.0 сая төгрөгийн дүн бүхий "Эрх зүйн туслалцаа үзүүлэх" гэрээг ЗДТГ-ын дарга нь төсвийн захирагчийг төлөөлөн байгуулж ажлын хөлсийг урьдчилж 100% олгосон ба үр дүн гараагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, Засгийн газрын 2016 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.8 дахь заалтыг тус тус зөрчиж Сум хөгжүүлэх сангаас олгосон 29 иргэний нийт 148.0 сая төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн хувийн хэргийг 2017 оны 01 дүгээр сард үрэгдүүлсэн гэх шалтгаанаар зээлийн үлдэгдлийг нотлох баримт байхгүй байна.
4	Баян-Овоо сумын ОНХС	Концессын тухай хуулийн 18.4 дэх заалтыг зөрчиж "Алтан завьяа ундрага" ХХК-тай 62.9 сая төгрөгийн "Сумын төвийн хаягжуулалт, цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэг"-ийн ажлыг гүйцэтгэх концессын гэрээ байгуулж 20.0 сая, "Хонгорын чандмань эрдэнэ" ХХК-тай 30.0 сая төгрөгийн "Гандангийн лам нарын орон сууцны барилгыг барих" концессын гэрээ байгуулж 15.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Төсвийн тухай хуулийн 6.4.2. дахь заалтыг зөрчиж, ОНХС-с "Гандангийн лам нарын орон сууцны барилгыг барих" арга хэмжээд 15.0 сая төгрөг зарцуулсан. Төсвийн тухай хуулийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчин өвс тэжээлийн орлогыг Сумын ИТХ-аар тодотгож

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

		батлаагүй байхад гүйцэтгэлээр орсон орлогоос "Хонгор шинэ агро" ХХК-д 1,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
5-9	Жинст, Баян-Өндөр, Бууцагаан, Бөмбөгөр, Богд сумын Сум хөгжүүлэх сан	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2.б-д заасны дагуу ИТХ-аас СХС-гийн төсвийг батлаагүй, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 216 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4 дэх заалтыг зөрчсөн нь "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
10	Баацаган сумын ОНХС	Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмын 6.1. дэх заалтыг зөрчин үүрэн телефоны сүлжээний төхөөрөмжийг барьж дуусаагүй, хүлээлгэн өгөөгүй байхад ОНХСангийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн, мөн барьж дуусаагүй хогийн төвлөрсөн цэгийн байгууламжийг эргэлтийн бус хөрөнгөөр бүртгээгүй, зардалд хааж бичсэн, тайлант жилийн балансад өмнөх оны авлагын 126,4 сая төгрөгийг хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд бүртгэсэн. Энэ нь материаллаг бөгөөд санхүүгийн тайлангийн "Хэмжилт", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргалаа.
11	Галуут сумын Засаг дарга	Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.2.5 дах заалтыг зөрчиж 2017 онд аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив болон бусад орлого 35,2 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүй, ЗДТГ-ын үндсэн болон нэмэлт дансанд оруулж зарцуулсан нь "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
12	Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги	2017 оны жилийн эцсийн тооллогоор бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 96,1 сая төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй нь "Оршин байх", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
13	Баянхонгор сумын 9-р цэцэрлэг	Нягтлан бодогч Н.Уламбаяр нь шийдвэргүйгээр 3 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 0,3 сая төгрөгийн бодож авсан, мөн 3-44-1 тоот хаягтай нэхэмжлэлээр 0,1 сая төгрөгийн цахилгааны төлбөрийг төсвөөс төлсөн, цалингийн урьдчилгаанаас 0,4 сая төгрөгийг төлөөгүй, авлагаар тусгаагүй. Бараа материалын тайланд 3 компанид 0,6 сая төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж, хүнсний материалыг орлого авсан. Шийдвэр гараагүй байхад эрхлэгч Ц.Чимэгсайханд нэг удаагийн тэтгэмжид 0,3 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, УИХ-ын 2017.11.09-ний өдрийн 67 тоот тогтоолын 1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн нь байгууллагын удирдлагаас санхүүгийн тайлангаараа дамжуулан гаргаж ирдэг батламж мэдэгдлүүдийг бүрэн хангахгүй байна.
14	Өлзийт сумын ЗДТГ	Санхүүгийн тайлангийн бараа материалд бүртгэлтэй 3,5 сая төгрөгийн өвс, 11,9 сая төгрөгийн мал амьтанг 2017 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тоолоогүй байгаа нь үнэн зөв байдал, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
15	Өлзийт сумын ИТХ	Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 7,0 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2,3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2017 оны 03 дугаар сард 1,2 сая төгрөгөөр патерей сольсон Приус-10 маркын автомашиныг унагаж эвдэлсэн байхад тооллогын бүртгэлд оршин байгаагаар бүртгэж, 2017 оны 11-12 дугаар сард элэгдэл тооцсон нь оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
16	Баян-Овоо сумын ЗДТГ	"Эм Би Би Импекс" ХХК-аас авсан өвсний үнэнд 2,2 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн атлаа түүнийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, тус аж ахуйн нэгжтэй тооцоо нийлсэн акт байхгүй, оны эцэст 12,6 сая төгрөгийн өвсийг тоолоогүй, тайлант онд 7,5 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, 4,8 сая төгрөгийн мал амьтанг байгууллагын даргын шийдвэргүйгээр бараа материалаас зарлагдсан зэрэг нь оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
17	Галуут сумын ЗДТГ	Тайлант онд аж ахуйн нэгжүүдээс 4,7 сая төгрөг хандиваар орсон байхад түүнийг орон нутгийн орлогод оруулж тодотгоогүй, аж ахуйн нэгжээс өгсөн хандив болон бусад орлогын 30,5 сая төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлэлгүй сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 27,0 сая төгрөгийг зарцуулсан нь "Тохиолдсон байх, Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
18	Баян-Овоо сумын Засаг дарга	Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлаагүй, Концессын тухай хуулийн 18.4 дэх заалтыг зөрчин 92,9 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ санхүүжүүлэхээр баталж, 35,0 сая төгрөг олгосон, Сум хөгжүүлэх сангийн төсвийг батлаагүй, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 8 төсвийн шууд захирагчдаас 3 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан зэрэг нь Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

19	Баянбулаг сумын ЭМТ	Тайлант хугацааны эмийн тайлан гаргаагүй, "Мягмар наран хишиг" ХХК-иас 2,7 сая хатуу түлшийг нярав авсан атлаа тайланд орлого, зарлагаар тусгаагүй байхад шилжүүлсэн мөнгөн дүнгээр санхүүгийн тайланд тусгаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн нь "Оршин байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
20	Аймгийн Түүх усаатны музей	1. Нягтлан бодогч ажилтны ээлжийн амралтын мөнгө олгоходоо нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын 0,6 сая төгрөгийг суутгаагүй, Татварын хэлтэст 0,08 сая төгрөгийг дутуу төлсөн, сахилгын шийтгэлтэй 4 ажилтанд Төрийн албан хаагчийн нэг удаагийн урамшуулал олгосон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Татварын ерөнхий хууль 18.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтууд, УИХ-ын 2017.11.09-ний өдрийн 67 тоот тогтоолын зэрэг заалтуудыг зөрчсөн. Мөн санхүүгийн тайланг хугацаа хожимдуулж ирүүлсэн.
21	Баянлиг сумын ЗДТГ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ" 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтыг зөрчин 2017 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгдээгүй нь "Оршин байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна
22	Шинэжинст сумын СХС	Сум хөгжүүлэх сангийн зээлийн нийт үлдэгдэл 123.5 сая төгрөг ба үүний 89.1 сая төгрөг буюу 72.1 хувь нь зээл төлөгдөх хугацаа хэтэрсэн нь "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
23	Бууцагаан сумын Баянбүрдний бага сургууль	Санхүүгийн тайлангаар хүнсний материалын тайлангийн үлдэгдэл эд хариуцагчийн тайлангаас зөрүүтэй, бичиг хэргийн болон шатахууны тайлан гаргаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга тооллогын бүртгэлээс 2,3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
24	Бууцагаан сумын сургууль	Санхүүгийн тайлангаар хүнсний материалын тайлангийн үлдэгдэл эд хариуцагчийн тайлангаас зөрүүтэй, бичиг хэргийн болон шатахууны тайлан гаргаагүй, тогтмол зардал /гэрэл цахилгаан, бусад зардал гэх мэт/-ыг материалын тайланд тусгаж стандарт бус бичилт хийсэн зэрэг нь оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Хүснэгт 15. "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" санал дүгнэлт авсан байгууллага:

№	"Дүгнэлт өгөхөөс татгалзсан" санал, дүгнэлт авсан ТШЗ	"Дүгнэлт өгөхөөс татгалзсан" санал, дүгнэлтийн шалтгаан
1	Баянхонгор сумын 6-р Цэцэрлэг	<ol style="list-style-type: none"> <li>Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Г.Чулуунцэцэг нь 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр нягтлан бодогчийн үүрэгт ажлыг хүлээлгэж өгөхдөө 2017 оны 01-03-р сарын нярвын бараа материалын хүнсний тайлан, хүнсний бараа материалын анхан шатны баримт хүлээлгэн өгөөгүй бөгөөд 2017 оны тайлант жилийн санхүүгийн тайланг гаргахдаа нягтлан бодогч Б.Бүрэнжаргал нь баримт дутуу байсан 01-03 дугаар сарын Бараа материалын хүнсний тайланг харилцахаас шилжүүлсэн мөнгө, хүүхдийн хоолны менюгаар тохируулан гаргасан гэх боловч шилжүүлсэн мөнгөн дүнгээс анхан шатны баримт, нэхэмжлэхийн дүнгүүд зөрүүтэй.</li> <li>2017.12.31-ны өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хагас жилээр тооцож тусгасан, үр дүнгийн тайланд нэмэгдэл цалингийн зардал хасах дүнтэй гаргасан байна. Дээрхи алдаа зөрчил нь санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</li> </ol>
2	Шинэжинст сумын "Жаргалант энх мөнх" Орон нутгийн өмчит ХХК	<ol style="list-style-type: none"> <li>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх нийтлэг зарчмуудыг зөрчиж оны эхний хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй</li> <li>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.1, 14.4.2 дахь заалтыг зөрчиж 2017 оны санхүүгийн тайланд тооллогоорхи эмийн үлдэгдэл, өмч, өр, авлагыг тусгаагүй</li> <li>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 дэх заалтыг зөрчиж санхүүгийн тайлангийн тодруулга тайлангууд бэлтгээгүй зэрэг зөрчлүүд нь "Оршин байх", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</li> </ol>

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаж дүгнэлт гаргасан 203 байгууллагаас 106 байгууллагын санхүүгийн тайланд ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй бөгөөд бусад байгууллагууд холбогдох хууль, тогтоомж, УСНББОУС,



Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит  
СТОУС, түүнтэй нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмыг зөрчсөнөөс нийт 2360,4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 794,8 сая төгрөгийн 125 алдааг санхүүгийн тайланд залруулж, 489,2 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байхад чиглэсэн 136 заалт бүхий зөвлөмжийг 68 байгууллагын төсвийн менежерт хүргүүлэв.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг зөрчин сахилгын шийтгэлийн хугацаа нь хүчинтэй байгаа ажилтнуудад төрийн албан хаагчид олгох нэг удаагийн мөнгөн урамшууллыг олгосон, зарцуулагдаагүй үлдэгдлийг зориулалт бусаар зарцуулсан, ажилтнуудад олгосон урьдчилгаа цалинг бүрэн суутгаагүй атлаа авлагаар бүртгээгүй, бэлтгэн нийлүүлэгчид үзүүлсэн ажил үйлчилгээний мөнгийг илүү төлсөн, ХХОАТ, НДШ-ийг бүрэн суутгаагүй, суутгасан татвар, шимтгэлийг тухай бүр төлөөгүй, өглөгөөр бүртгээгүй, СХС-гаас зээл аваад гэрээнд заасан хугацаанд төлөөгүй зэргээр хууль тогтоомж зөрчсөн 254,6 сая төгрөгийн зөрчилд 89 төлбөрийн акт тогтоож, төсвийн болон бусад эх үүсвэрээр худалдан авсан хөрөнгө, бараа материалыг орлогод аваагүй буюу буруу ангилалд бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг зөрүүтэй хийсэн, СХС-гийн хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулаагүй зарцуулсан, сангаас авсан зээлийг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ аваагүй зэрэг 821,8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 45 албан шаардлага өгөв.

Илэрсэн алдааны хэмжээ өмнөх оноос 673,0 сая төгрөгөөр өссөний дотор зөрчил арилгах албан шаардлагын дүн 694,4 сая, төлбөрийн акт 44,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь сумдын ОНХС, СХС-д аудит хийж бие даасан дүгнэлт гаргасан ба СХС-гаас зээл авсан иргэд өмнөх онуудад авсан зээлээ гэрээнд заасан хугацаанд төлөөгүй байхад түүнийг төлүүлэх талаар арга хэмжээ аваагүй байсан тул хугацаа хэтэрсэн зээлийг холбогдох журам, гэрээний дагуу төлүүлж, зөрчлийг арилгуулахаар 821,9 сая төгрөгийн албан шаардлага өгсөн нь нөлөөлсөн боловч аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлдэггүй, бүх шатанд төрийн албан хаагчдын хариуцлага, сахилга, төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналт сул, холбогдох хууль, дүрэм, журмыг бүрэн хэрэгжүүлдэггүй, санхүүгийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварт төдийлөн ахиц гарахгүй байгаатай холбоотой өмнөх онуудад гарч байсан зөрчил дутагдлууд бүрэн арилахгүй, дахин давтагдан гарч байна.

Аудитын дүнд үндэслэн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” болон “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авсан 17 байгууллагын төсвийн менежерт Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 28.1-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулах саналыг томилсон албан тушаалтанд хүргүүлэв.

**Арван хоёр. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэгдсэн төсөл, сангийн талаар**

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Орон нутаг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Замын сан зэрэг 5 сан нэгтгэгдсэн байна.

Аудитаар ажиглахад зарим сумдын ОНХС, СХС-гийн 2-р гарын үсгийг Санхүүгийн албаны дарга, аймгийн Замын сан, ОНХС-ийн дансны 2-р гарын үсгийг аймгийн Ерөнхий нягтлан бодогч нар зурж санхүүгийн тайланг гаргаж, түүнийг хянаж санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргаж байгаа нь “Нийтийн албанд нийтийн олон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1<sup>5</sup> дэх заалттай нийцэхгүй байна.

**12.1 Төсөл, сангуудын мөнгөн хөрөнгийн талаар**

2017 оны жилийн эцсийн байдлаар сум хөгжүүлэх сан 832.3 сая, ОНХС 747,4 сая, замын сан 43,5 сая, байгаль хамгаалах сан 2.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөл сангийн мөнгө хөрөнгийн үлдэгдэл 754.7 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнээс төрийн санд 679.1 сая төгрөг нь хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 622.9 сая, орон нутгийн нөөц сангийн дансанд нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн 56.2 сая төгрөгийг байршуулсан байна. Арилжааны ХАС банкинд жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор байршуулсан 75.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

**Хүснэгт 16. Төсөл сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл**

Сум	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл					Сум	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
	СХС	ОНХ сан	Замын сан	МХС	БХ сан		СХ сан	ОНХ сан	Замын сан	МХС	БХ сан
Баянхонгор аймаг		3,2				Бөмбөгөр	0,3	120,4	43,5		
Баянхонгор	266,4	28,1			2,8	Бууцагаан	14,3	94,9			

<sup>5</sup> “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”

**Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит**

Өлзийт	22,3	7,7			Хүрээмарал	4,3	3,8		
Жинст	36,1	5,1			Баянбулаг	16,5	33,8		
Богд	62,4	41,0			Гурванбулаг	19,5	5,1		
Баянлиг	31,0	50,8			Заг	11,9	94,5		
Баянговь	38,9	22,9			Жаргалант	27,4	50,2		
Шинэжинст	70,2	4,4			Галуут	61,2	54,1		
Баянөндөр	36,0	6,3			Баяновоо	3,2	1,0		
Баянцагаан	49,0	30,3			Эрдэнэцогт	50,7	41,7		
Баацагаан	10,7	48,1							
Нийт дүн						832,3	747,4	43,5	2,8

## **12.2 Төсөл, сангуудын авлага, өр төлбөрийн талаар**

**12.2.1. Орон нутгийн хөгжлийн сан:** 2017 онд тус аймагт ОНХНС-гаас 2163,3 сая төгрөг хуваарилсныг аймгийн ИТХ-ын 2016.12.02-ны өдрийн хуралдааны 4/02 дугаар тогтоолоор анх 2980,0 сая төгрөгөөр баталж, аймгийн ИТХ-ын 2017.06.02-ны өдрийн хуралдааны 6/2 тоот тогтоолоор 2163,3 сая төгрөгөөр тодотгон 816,7 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2017 онд улсын төсвөөс аймгийн ОНХНС-нд 2163,3 сая төгрөгийн санхүүжилт олгосныг аймгийн ОНХС-д 1551,1 сая, сумын ОНХС-д 28,3 хувь буюу 612,2 сая төгрөгийг олгосон байна.

2017 оны эхэнд ОНХС нь 892,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба ОНХНСангаас 2163,3 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 373,0 сая, хандив, тусламж бусад орлогоор 2640.8 сая, нийт 5177.1 сая төгрөгийн орлого орж, 5322.2 сая төгрөгийг төсөл, арга хэмжээний зардалд зарцуулж, оны эцэст 747.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 10 байгууллагад 80,7 сая төгрөгийн зөрчил илэрч 13 зөвлөмж, 9 байгууллагын санхүүгийн тайланд 116,0 сая төгрөгийн залруулга хийж, 7 байгууллагад 12,2 сая төгрөгийн төлбөрийн акт, 3 байгууллагад 26,1 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

ОНХСангийн хөрөнгийг зарцуулахдаа холбогдох хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлээгүй зөрчил байсаар байна. Тухайлбал:

- Шинэжинст, Богд, Баянцагаан зэрэг ихэнх сумд Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын хавсралт 4-д заасан "урсгал засварын ажлын гүйцэтгэл"-ийг холбогдох маягтын дагуу гаргаж, баталгаажуулаагүй байхад Төрийн сан гүйлгээ хийж санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, журам зөрчсөн байна.

- Гурванбулаг сум Сумын ИТХ-аас баталгдаагүй төсөл арга хэмжээ буюу Цагдаагийн тасагт бэлэн бусын тоног төхөөрөмжийг 2,3 төгрөгөөр гэрээ байгуулан 2,0 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

- Өлзийт сумын ОНХС "Баян тээх" ХХК-иас гэрээнд тусгасан зардлаас зураг төсвийн үнийн 3,8 сая, захиалагчийн хяналтын зардлын 2,0 сая төгрөгийг суутган тооцоогүй илүү шилжүүлсэн.

- Бөмбөгөр сумын ОНХС Нийгмийн халамж, асрамж үйлчилгээнд батлагдсан 1,0 сая төгрөгийг НИК ХХК-д шилжүүлсэн анхан шатны баримт байхгүй.

- Бөмбөгөр сум ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 18,0 сая төгрөгийн өвсийг ЗДТГ-ын тайланд тусгасан атлаа сангийн тайланд авлагаар бүртгэсэн.

- Бөмбөгөр сум ажлын урьдчилгаанд шилжүүлсэн 25,3 сая, Жаргалант сум худаг засварын 14.8 сая, Богд сум сургуулийн засварын зураг төсвийн үнэ 9.0 сая, Баянцагаан сум багийн төвд гэрэлтүүлэг тавих ажилд 9,5 сая төгрөгийг тус тус олгож хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгөөр бүртгээгүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 6.1-т " УТХО-аар хийгдсэн ажил нь ...орон нутгийн өмчид заавал бүртгэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусан хүртэл...захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана..." гэсэн заалтыг зөрчсөн

- Галуут сумын ОНХС Сумын ЗДТГ-ын автомашины засварын 2,6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн.

- Баянцагаан сум Үүрийн говь ХХК-иас сумын нутагт нөхөн сэргээлт хийх зорилгоор барьцаа хөрөнгө 30,3 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлж үйл ажиллагаа явууллаагүй байхад өглөгөөр тайланд тусгаагүй.

- Заг сум тайлант онд олгосон малжуулах зээлийн 16,2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.

#### **12.2.2. Сум хөгжүүлэх сан:**

Баянхонгор аймгийн 20 сумын Сум хөгжүүлэх сангийн дансанд 2017 оны эхэнд 659.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоос 1309,0 сая төгрөгийн орлого орж, ЖДҮ эрхлэгч 189 иргэн, аж ахуйн нэгжид 1104,5 сая төгрөгийг зээлд олгож, сангийн үйл ажиллагааны зардалд 19,3 сая, бусад зардалд 12,1 сая төгрөг зарцуулан оны эцэст 832,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2017 оны эцсийн байдлаар санхүүгийн нэгтгэсэн тайланд СХС-гаас хувь хүмүүст олгосон зээлийн 3791,2 сая төгрөгийн авлагатай байна.

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар зээлийн хүү, зээлийн авлагыг тайланд зөрүүтэй тусгасан, сангаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан, зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зэрэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

Аймаг, сумдын СХС-ийн зарцуулалтад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 8 байгууллагад 12,1 сая төгрөгийн зөрчил арилгах 11 зөвлөмж, 4 байгууллагын санхүүгийн тайланд 9,8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 7 байгууллагад 158,4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 16 байгууллагад 668,5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

- Баянговь сум сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэгч болох ЭЙ АР БИ СИ ХХК-д 10.0 сая төгрөгийн зээлийг сум хөгжүүлэх сангаас олгосон.

- *Жаргалант сум Шүүхээр шийдвэрлүүлэн мөнгө нь өмгөөлөгчийн дансанд орж ирсэн 3 иргэний Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлбөр болох 2,8 сая төгрөгийг өмгөөлөгч СХС-ийн дансанд төвлөрүүлээгүй байна.*

- *Бөмбөгөр сумын СХС-гаас зээл авсан 15 хүн 23,1 сая, Өлзийт сумын СХС-аас зээл авсан 19 хүн 11,3 сая, Хүрээмарал сумын СХС-аас зээл авсан 2 иргэн 13,8 сая төгрөгийн зээлийг 2017 онд төлөх хуваарь хийсэн боловч зээлийн гэрээний дагуу төлөлгүй зээлийг хугацаа хэтрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна..*

- *Баян-Овоо сум Сум хөгжүүлэх сангаас сумын ИТХ-аас сангийн төсвийг баталж өгөөгүй байхад ЗДТГ-ын дарга, иргэн Б.Батцэнгэлтэй 12.0 сая төгрөгийн дүн бүхий "Эрх зүйн туслалцаа үзүүлэх" гэрээ байгуулан 12.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон*

- *Баяновоо сум 136,0 сая, Жаргалант сум 49,9 сая, Баянцагаан сум 15,6 сая, Баянлиг сум 17,1 сая, Заг сум 56,9 сая, Бууцагаан сум 44,1 сая, Бөмбөгөр сум 92,7 сая, Шинэжинст сум 15,7 сая, Богд сум 9,9 сая, Баянбулаг сум 54,8 сая, Баянговь сум 86,8 сая, Жинст сум 38,4 сая, Баацагаан 38,1 сая нийт 635,5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хуваариас хугацаа хэтэрсэн зээлдэгч нараар зээлийг төлүүлэх, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.*

Сумын Засаг дарга нар Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээл авсан болон зээлийн үлдэгдлийн мэдээллийг Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4<sup>6</sup> дэх заалтыг зөрчснөөс Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах нөхцлийг бүрдүүлээгүй байгаа тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

### **12.2.3. Авто замын сан:**

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016.12.02-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 310.2 сая, орон нутгийн автозам ашигласны төлбөрөөр 90.0 сая төгрөгөөр баталж, 2017.11.27-ы өдрийн 7/01 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 428.7 сая, орон нутгийн автозам ашигласны хураамжийг 116.1 сая төгрөгөөр тодотгосон байна.

Орон нутгийн орлогод АТБӨЯХАТ-ын орлогоор 399.7 сая төгрөг төвлөрсөн ба ба авто замын санд 374,2 сая төгрөг авахаар төлөвлөж, 380.0 сая төгрөгийг замын санд санхүүжилтээр олгосон байна.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-ын орлогоос 380.0 сая төгрөгийн санхүүжилт авч, авто зам ашигласны хураамжийн орлогоор 117.4 сая, нийт 517.1 сая төгрөгийн орлого төвлөрснөөс 25 батлагдсан төсөл, арга хэмжээнд 475.3 сая төгрөгийн зардал гаргаж 43.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

<sup>6</sup> "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4 " Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг... аймгийн Засаг даргад хүргүүлнэ" АУДИТЫН КОД БНА-2018/1/СТА-ТЕЗ

**Арван гурав. Орон нутгийн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн байдлын талаар**

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд: Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсрол, Соёлын үйлчилгээ, Нийтийн биеийн тамир, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ.

2017 онд ЭМС, ХАХНХС, БХБС, БСШУС-ын төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутагт байршилтай харьяа 113 байгууллагад 38651,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос оны эцэст харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 37.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17. ТЗШ-ийн байгууллагуудад олгосон санхүүжилт, төвлөрүүлэлт /сая.төг/

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:			
		БСШУС-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	БХБ-ын сайд
Батлагдсан төсөв	38,651.3	32,807.2	145.4	5,454.5	244.1
Олгосон урсгал санхүүжилт	38,651.3	32,807.2	145.4	5,454.5	244.1
Нийт төвлөрүүлсэн	37.4	23.9	0.1	12.4	1.0
Үүнээс:Төсөвт /СЯ/	37.4	23.9	0.1	12.4	1.0

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь нийт 87333.6 сая төгрөгийн хөрөнгөтэй байна.

Хүснэгт 18. Тусгай шилжүүлэгийн байгууллагын хөрөнгийн задаргаа /сая.төг/

Үзүүлэлт	Нийт дүн		Үүнээс:			
	2016 онд	2017 онд	ЭМС-ын сайд	ХАХНХ-ын сайд	БСШУ-ын сайд	БХБ-ын сайд
Мөнгөн хөрөнгө	1.2	31.6	31.6			
Авлага	81.2	42.6	6.8	0.6	35.2	
Бараа материал	2,850.5	3,492.3	421.2	11.3	3,034.2	25.6
Нөөцийн бараа	131.3	141.3	1.7		139.6	
Үндсэн хөрөнгө	80,128.4	83,625.8	13,505.6	88.2	69,735.8	296.2
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>83,192.6</b>	<b>87,333.6</b>	<b>13,966.7</b>	<b>100.2</b>	<b>72,944.8</b>	<b>321.8</b>
Өр төлбөр	12.1	50.3	37.8	-	12.4	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	83,180.5	87,283.3	13,928.9	100.2	72,932.4	321.8
<b>Өр төлбөр цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>83,192.6</b>	<b>87,333.6</b>	<b>13,966.7</b>	<b>100.2</b>	<b>72,944.8</b>	<b>321.8</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх онд 81,2 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлант онд 38,6 сая төгрөгөөр буурч 42,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Харин өглөг оны эцэст 50,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос 38,2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн салбарын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

## Арван дөрөв. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бүртгэл, тайлагнал

### 14.1. ОНӨҮГ-ын бүтцийн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ОНӨҮГ-ууд болох Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК, Чандмань-Баянхонгор ХК, Цэвэр хот ХХК, Нью майнинг ОНӨҮГ, Үйдвэржүүлэлт корпораци ХХК, сумдын Эмийн эргэлтийн сангийн нэгтгэсэн тайлан зэрэг нийт 6 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Хүснэгт 19. ОНӨҮГ-ын 2017 оны орлого, зарлага, хуримтлагдсан үр дүн

дд	ААН нэр	тоо	Орлого	Зарлага	2017 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Баянхонгор Эрчим хүч ХХК	1	6,681.8	6,327.5	354.4	(2,241.6)	(1,887.2)
2	Чандмань Баянхонгор ХК	1	1,120.2	1,002.6	117.5	276.6	394.1
3	Цэвэр хот ОНӨҮГГазар	1	381.1	335.3	45.8	(101.5)	(55.7)
4	Эмийн эргэлтийн сан	1	1,376.3	1,486.8	(110.4)	542.7	432.3
5	Нью майнинг ХХК	1	171.7	159.8	11.9	-	11.9
6	Үйдвэржилт хөгжлийн корпораци ХХК	1	655.5	646.1	9.4	-	9.4
	Нийт	6	10,386.7	9,958.1	428.6	(1,523.7)	(1,095.1)

сая.төг

Дээрх хүснэгтээс харахад Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагууд нийт дүнгээрээ 428,6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Эдгээр байгууллагаас Эмийн эргэлтийн сан 110,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өмнөх онд Чандмань-Баянхонгор ХК 38,7 сая, Цэвэр хот ОНӨҮГ 38,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол тайлант онд ашигтай ажилласан байна.

Аймгийн Эмийн эргэлтийн сан нь сумдын Эмийн эргэлтийн сангийн эмийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас татан авч аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эмийн эргэлтийн санд олгодог ба Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3<sup>7</sup> дахь заалтыг зөрчиж арилжааны ХААН банкинд Эрүүл мэндийн газар Эмийн эргэлтийн сан гэсэн харилцагчийн нэрээр 5225206910 тоот дансаар гүйлгээ хийгдсэн байна. Харилцах дансны гүйлгээ хийх 1-р гарын үсгийг аймгийн ЭМГ-ын

<sup>7</sup> “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” АУДИТЫН КОД БНА-2018/1/СТА-ТЕЗ

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит дарга А.Ганболд, 2-р гарын үсгийг Н.Энхбаяр нар зурж хөрөнгө мөнгийг зарцуулсан байна.

Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан 2017 онд санхүүгийн тайлан гараагүй Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тухайн харилцах дансны орлого, зарлагын гүйлгээгээр бичилт хийж, харилцах дансны үлдэгдэл 98,3 сая төгрөгийг тайланд өглөгөөр тусгасан байна.

Өмнөх онуудад нягтлан бодогч Энхбаяр Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргахдаа дээрх Эрүүл мэндийн газрын ЭЭС-ийн санхүүгийн тайланг гаргаагүй, нэгтгэлд оруулаагүй байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Эрүүл мэндийн газар Эмийн эргэлтийн сан данс 2017.12.31-ны байдлаар 98,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 2018 оны 1-р сарын 01-18-ны хооронд дээрх мөнгийг эмийн өр нэрээр байгууллагуудад шилжүүлж, дээрх харилцах данс үлдэгдэлгүй болсон байна.

Иймд дээрх байгууллагын 3 жилийн үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагаар шалгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Мөн аймгийн Эмийн эргэлтийн сангийн тайланг гаргаагүй ЭМГ-ын дарга А.Ганболдод аймгийн хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

#### **14.2 Орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар**

**Эмийн эргэлтийн сангийн нэгтгэсэн санхүүгийн тайланг** өмнөх нягтлан бодогч өөрчлөгдсөнөөр 2017 оны жилийн эцсийн тайланг хугацаа хоцроож аудит хийлгээгүй.

Үүний улмаас сумдын ЭЭС-ийн тайланг нэгтгээгүй хугацаа хоцорсноос аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хугацаа хоцорч хүндрэл учирсан.

Эмийн эргэлтийн сангийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг Шинэжинст сум "Мандалгоо фарм" ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх нийтлэг зарчмуудыг зөрчиж оны эхний хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй, 2017 оны санхүүгийн тайланд тооллогоорхи эмийн үлдэгдэл, өмч, өр, авлагыг тусгаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1 дэх заалтыг зөрчиж санхүүгийн тайлангийн тодруулга тайлангууд бэлтгээгүй зэрэг зөрчлүүд нь "Оршин байх", "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байснаас аудитаас **"Дүгнэлт өгөхөөс татгалзсан"** дүгнэлт өгч, бусад газрууд Зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.



ОНӨААН-ийн дүнгээр нийт 111,5 сая төгрөгийн зөрчил илэрч 61,3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 3,6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36,5 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 14 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### Арван тав. Орон нутгийн нэмэлт санхүүжилтийн дансны талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн нэмэлт санхүүжилтын дансаар 1822,7 сая төгрөгийн орлого орж 50,7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 1772,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт дансанд хандив тусламжийн орлогоор 141,9 сая, ангилагдаагүй зардлын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид зохих шийдвэрийн дагуу 211,2 сая төгрөг, дээд шатны шатны төсвийн захирагчаас 1416,0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 53,6 сая төгрөг нийт 1822,7 сая төгрөгийн орлого орсон байна.

Дээрх орлогоос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-д 72,3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1602,6 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 97,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

### Арван зургаа. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

2017 онд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2016 оны аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6 заалт бүхий зөвлөмж өгч, 62,8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 259,1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсний дагуу зөрчлийг арилгасан бөгөөд Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 1а/669 тоот албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлсэн ба биелэлт 90,0 хувьтай байна. Хүснэгт 20. Зөвлөмжийн хэрэгжилт

№	Зөвлөмжийн агуулга	Биелэлт	Хэрэгжилтийн байдал
1	Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулахдаа зөвхөн аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын дүнгээр бус сумын төсөвт төвлөрөх татварын орлогын дүнг оруулан аймгийн төсвийн суурь орлогын дүнгээр өргөн барьж, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтлах, сумын ИТХ-ын төсвийн орлогын тодотголуудын өөрчлөлтийг аймгийн Татварын хэлтсийн төлөвлөгөөнд тусгуулах.	Хэрэгжилт 80 хувь	Аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-аар батлагдсан дүнг Фискаль программд шивж сан үүсгэн нэгтгэлийг Сангийн яаманд тухай бүр нь хүргүүлж, файл үүсгэн хадгалсан байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тухайн сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн тайлант онд тухай бүрд нь төсвийн тодотголоор оруулан батлуулж, Татварын хэлтэст өөрчлөгдсөн хуваарийг хүргүүлэн ажиллаж байгаа ч аудитаар татварын мэдээг зөрүүтэй тайлагнасан байна.
2	Сумдын засаг дарга нар СХС-ийн батлагдсан төлөвлөгөөг биелүүлж,	Хэрэгжилт 50 %	СХС-ийн төлөвлөгөөг хийхдээ зээлийн эргэн төлөлтийн бодит байдалд тулгуурлаж хийх

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит

	сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг 2017.06.20-ний дотор барагдуулан санд төвлөрүүлэн, зээлийн авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.		талаар зөвлөмжийг өгч "Бүтээлч санхүүч" аяны хүрээнд зээлийн эргэн төлөлтийг барагдуулах, хугацаа хэтэрсэн зээлийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр албан хүргүүлж ажиллаж байгаа боловч зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.
3	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон 599.3 сая төгрөгийн ЖДҮ-ийн зээлийн эргэн төлөлтийн дутуу, малчдыг малжуулахаар Төрийн сангаар дамжуулан олгосон 73.2 сая, Сангийн яамнаас аймгийн Төрийн санд хийсэн шалгалтаар илэрсэн гэрээний дагуу Скейл ХХК-иас авах 195.0 сая, Хаш гоёо ХХК-аас авах цэцэрлэгийн барилгын урьдчилгаа санхүүжилтийн 39,0 сая, нийт 906.5 сая төгрөгийн авлагыг 2017.06.20-ны дотор барагдуулах арга хэмжээ авч, хугацаандаа барагдаагүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэх.	Хэрэгжилт-70 хувь	ОНХС-с олгосон зээлийн эргэн төлөлтийг барагдуулах талаар аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн Эрдэнэ-Оюунд үүрэг болгосон байна. 1. ОНХС-ийн зээлийн үлдэгдэл 2017.12.31-ны байдлаар 37.4 сая төгрөгийг барагдуулж 501.9 сая төгрөг байгаа ба зээлдэгч нарыг хуулийн байгууллагад хандан ШШГА-д шилжүүлсэн байна. 2. Малчдыг малжуулахаар Төрийн сангаар дамжуулан олгосон 73.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар сумдад албан тоот хүргүүлэн холбогдох шийдвэр гаргуулж барагдуулсан. б/. Сангийн яамнаас аймгийн Төрийн санд хийсэн шалгалтаар илэрсэн гэрээний дагуу Скейл ХХК-иас авах 195.0 сая төгрөгийн авлагыг орон сууцанд орсон айлуудын судалгааг авч асуудлыг судлан аймгийн ИТХ-д асуудлыг тавьсан шийдвэр хараахан гараагүй байна. в/ Хаш гоёо ХХК-аас авах цэцэрлэгийн барилгын урьдчилгаа санхүүжилтийн 39,0 сая төгрөгийн авлагын 32.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу ХО-ын буцааж олгох мөнгийг суутган тооцож, үлдэгдэл 7.0 сая төгрөгийг ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ажлын санхүүжилтээс суутган тооцоо хийж барагдуулсан.
4	"Чандмань-Баянхонгор" ХК, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХК-ийн балансад бүртгэлтэй гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 1030,9 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулж, хугацаа хэтэрсэн 182.7 сая төгрөгийг гэрээний дагуу төлүүлэх арга хэмжээ авч, гэрээний үүргээ биелүүлж ажиллах.	Хэрэгжилт 80 хувь	Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлээс: 1. "Чандмань-Баянхонгор" ХК нь МОН-1847 төслөөр 99.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй одоогоор тооцоог нийлж актаар баталгаажуулаагүй байна. 2. Харин "Баянхонгор-Эрчим хүч" ЦТ ХК-ийн балансад бүртгэлтэй МОН-1847 төслийн 36.3 сая, МОН-3503 төслийн 895.3 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдлийг 2016.12.31-ны байдлаар тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулсан, 2017 оны эцсийн байдлаар 858,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан, тайлант онд 49,0 сая төгрөг хуваарийн дагуу төлсөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2017.10.01-ны байдлаар 182.7 сая төгрөг байгаа ба үүнийг төлөөгүй энэ онд төлөх график гаргасан.
5	Батлагдсан төсвийг зардлын зүйлээр зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланд гарсан зардлыг эдийн засгийн ангилалаар зөв бүртгэн, Төсвийн тухай хуулийн 6.4.8-т заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн зарчмыг хэрэгжүүлэн авлага, өглөгийг барагдуулж, сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээг хүлээн авсан актаар санхүүгийн тайланд бүртгэж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т заалтыг хэрэгжүүлж ажиллах.	Хэрэгжилт 100%	НББ-ийн тухай хуулийн 14.4.2-т заасны дагуу өглөг, авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгуулж, батлагдсан төсвийн дагуу зарцуулалтад хяналт тавьж, Төсвийн тухай хуулийн 42-т заасны дагуу тухайн байгууллагын хүсэлтийг авч төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийж сар бүр хуваарийг шинэчлэн хийж Сангийн яаманд хүргүүлж ажиллаж байна. 2017 оны 3-р улирлын санхүүгийн тайланг төсвийн ерөнхий хя-бо, мэргэжилтэн нар шалгаж хүлээн авч оны эцэст өр, авлагагүй гаргах тал дээр анхаарч зайлшгүй хийх төсвийн тодотгол, зохицуулалтыг нэгтгэн гаргаж холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

**Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудит**

6	Төсвийн байгууллага, сан, сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланг аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэс Төсвийн тухай хуулинд заасан цаглабарт заасан хугацаанд үнэн зөв, алдаагүй, иж бүрэн гаргах тал дээр анхаарч, санхүүгийн тайлан гаргах сургалтыг сумдын Санхүүгийн албаны дарга нарт явуулж, үр дүнг тооцох	Хэрэгжилт 100%	Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гаргах, цаашид анхаарах асуудлын талаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газруудтай хамтран сумдын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогчдыг хамруулсан нэгдсэн сургалтыг 2017 оны 6, 8-р саруудад 2 удаа хийж давхардсан тоогоор 143 хүн хамрагдсан байна. Мөн Тогтвортой амьжиргаа төсөл, СТСХ, Төрийн аудит, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хамтран 2017.10.16 онд Галуут суманд, 10.18-нд Жинст суманд бүсийн сургалтыг сумдын 80 санхүүгийн ажилтнуудыг хамруулан явуулав.
Нийт хэрэгжилтийн дундаж хувь		80%	
Хэрэгжсэн зөвлөмжийн тоо		2	
Дутуу хэрэгжсэн зөвлөмжийн тоо		4	

**Арван долоо. Санхүүгийн тайланд гэрээгээр хийлгэсэн аудитын талаар**

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан “Хонгорын үр сад аудит”, “Глобал капитал аудит” компаниудтай 43 байгууллагын санхүүгийн тайланд гурвалсан гэрээ байгуулж аудит хийлгэв.

Дээрхи 2 компани нь гэрээнд заасан хугацаанд аудитыг гүйцэтгэж, аудитын дүгнэлт, ажлын баримт материалуудыг хугацаанд нь ирүүлэв.

**Арван найм. Аудитын санал дүгнэлтийн талаар**

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 271.7 сая төгрөгийн зөрчил илэрч 142,8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 28,9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 99,4 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн тул “Зөрчилгүй санал дүгнэлт” өгөх саналыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт уламжилж байна.

**Арван ес. Менежментийн захидал**

*Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал,  
аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа,  
төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц. Самбууням нар танаа*

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

1. Байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2860.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч өмнөх оноос 673.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, алдаа, зөрчил буурахгүй байгаа тул Нягтлан бодох бүртгэлийн болон цалингийн программын ашиглалтыг сайжруулж, нягтлан бодогч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх.
2. Сум хөгжүүлэх сан, ОНХС-аас ЖДҮ хөгжүүлэх зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулан, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах тал дээр сумдын Засаг дарга нарт үүрэг өгч, үр дүнгийн гэрээний үзүүлэлт болгон оруулах.
3. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 5.4-дэх заалтыг хэрэгжүүлэн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого, зарлага, зээлийн үлдэгдлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах.
4. Үйдвэржилт хөгжлийн корпораци ХХК, Нью майнинг ХХК-нийг цаашид үйл ажиллагааны орлогоор зардлаа нөхөж ажиллах бодлого барьж, төсвөөс олгох дэмжлэгийн хэмжээг зогсоож, үр ашгийг нэмэгдүүлэх .
5. "Цэвэр хот" ОНӨҮГ, "Баянхонгор Тохижилт үйлчилгээ" ХХК-ийн статусыг хуульд нийцүүлэн тодорхой болгох.
6. Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь заалтыг зөрчиж нээсэн ХААН банкинд байрших аймгийн ЭМГ-ын эмийн эргэлтийн сангийн дансыг хааж, тухайн дансаар өмнөх онуудад гарсан үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагаар шалгуулах.
7. Гадаад зээлийн хөрөнгөөс дамжуулан зээлдүүлсэн Чандмань-Баянхонгор ХК, Баянхонгор Эрчим хүч ЦТХК-ийн зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж

баталгаажуулах, хугацаа хэтэрсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллах.

8. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын байгууллагад хугацаанд нь хүргүүлэх талаар хяналт тавьж ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил түүний хэрэгжилт үр дүнгийн тайланг, холбогдох баримтын хамт 2018 оны 07 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## Хорь. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, Т  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ  
Г.БАТЖАРГАЛ ТАНАА

2018.04.19 № 2/227

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил

D:\Gerchilgee\_STA\Bayankhongor aimgiin TEZ.docx

2518439

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

